



МОНГОЛ УЛС БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2001 оны 01 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хог
Утас: 322480
Факс: 976-1-323158

Оюутан Н.Сарнайг үргэлжлүүлэн суралцуулах тухай

Соёл, урлагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого алдагдаж ирсний улмаас боловсон хүчин дутагдаж хот-хөдөөгийн театр-чуулга, киноны байгууллагуудын үйл ажиллагаанд бэрхшээл учирч байгааг харгалзан ТУШААХ НЬ:

Өндөр хөгжилтэй орнуудад нарийн мэргэжлийн найруулагч бэлтгэх зорилгоор АНУ-ын Чикаго хотын Колумби Кино Коллежийн кино найруулагчийн ангид 1997 онд шалгуулан орж амжилттай суралцан, энэ жил 4-р курс төгсөх гэж байгаа Нямгаваагийн Сарнайг өнөөгийн кино урлагийн хөгжил байдал, цаашид яаралтай боловсон хүчин шаардлагатай байгааг харгалзан 2000-2001 онд үргэлжлүүлэн суралцуулахыг зөвшөөрсүгэй.

Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

A. Tsamjid

А.ЦАНЖИД